



Глоб Интернэшнл
ТББ

"ХҮНИЙ ЭРХИЙН МЭДЭЭЛЛЭЭР ДАМЖУУЛАН ИРГЭНИЙГ ЧАДАВХЖУУЛАХ НЬ" ТӨСЛИЙН ХҮРЭЭНД БЭЛТГЭВ



Их Британий
ЭСЯ

Глоб Интернэшнл ТББ, "Хүүхдийн эрх хамгаалал" төв, Монголын ТББ-ын форум

САНАЛ

ХҮҮХДИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАЖ, БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТӨХГҮЙ БАЙХ НӨХЦЛИЙГ БИЙ БОЛГОХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА

Сүүлийн жилүүдэд Улаанбаатар хотод хүүхдийн эрхийн зөрчил, тэр дундаа бэлгийн болон бусад хэлбэрийн хүчирхийлэл нэлээд өсч байна. 2010 онд хүчингийн 345 гэмт хэрэг бүртгэгдсэний 154 нь нийслэлд гарчээ. Хүчингийн гэмт хэргийн хохирогчдын дийлэнх нь сургуулийн бага нас, өсвөр насын хүүхдүүд байна. Тус онд 17 нас хүртэлх 152 хүүхэд хүчингийн гэмт хэргийн золиос болж бие махбод, сэтгэл санааны хувьд хүндээр хохирчээ. Эдгээр хүүхдүүдийн 118 нь сургуулийн сурагч, 7 нь сургууль завсардсан охицууд байна. 2010 онд үйлдэгдсэн нийт гэмт хэргийн хохирогчдын дунд 17 нас хүртэлх хүүхэд 1066 байна.

Бэлгийн хүчирхийлийн хохирогч хүүхдүүд ихэвчлэн хичээл тараах үеэр буюу 18:00-19:00 /22:00/ цагийн хооронд, харанхуй гудамжинд гэмт хэрэгт өртөж байна. Мөн хүүхдүүд хүчингийн гэмт хэргийн золиос болоход хотын нийтийн тээврийн хэрэгслийн зохицуулалт нөлөөлж байна. Учир нь сүүлийн жилүүдэд иргэдэд хотын захад газар олгох болсон ч, нийтийн тээврийн үйлчилгээ шаардлага хангахгүй байгаа. Жишээлбэл, Хүүхдийн эрх хамгааллын төвөөр үйлчлүүлж байгаа СХД-ийн 22-р хорооны Тахилт хэмээх газарт оршин суугч иргэний мэдээлснээр, тэнд хотын нийтийн тээврийн зөвшөөрөлтэй 2 ширхэг микро автобус л үйлчилдэг бөгөөд тэдгээр нь өглөө хотын төв рүү орохдоо буудал бүрээс зорчигчоо авдаг хэрнээ, эргээд Тахилт руу явахдаа зөвхөн 1-р хорооллын Саппорто буудлаас хүнээ дүүргэж, бусад замын буудал дээр зогсохгүй, эцэс хүрдэг. Иймээс тэндхийн иргэд гэр рүүгээ 5-8 км газрыг 2-3 уул давж алхахад хүрдэг бөгөөд сургуулийн хүүхдүүд ч мөн ийм байдлаар гэр рүүгээ буцдаг. Энэ нөхцөл байдлаас болж 9 настай охин өдөр хичээл тарж, гэр рүүгээ явах замдаа хүчиндүүлсэн хэрэг гарсан.

Дээрхи нөхцөл байдалд үндэслэн, дараах саналыг хүргүүлж байна.

1. Эрүүгийн хуулийн 126.3-т 14 хүртэлх насын хүүхдийг хүчиндсэн гэмт хэргийг онц хүнд гэмт хэрэгт тооцож байгааг "16 хүртэлх" хэмээн өөрчлөх
2. ЕБС-ийн үдээс хойш хичээллэдэг ангийн сурагчид аливаа гэмт хэргийн хохирогч болох нь түгээмэл байгааг анхаарч энэ чиглэлээр хүүхэд хамгааллын тусгай бодлоготой болох
3. ЕБС-ийн орчинд үйлдэгдсэн гэмт хэрэгтэй холбогдуулан сургуулийн удирдлагад хариуцлага тооцдог болох
4. Сургуулийн болон байшин, гэр хорооллын ойр орчим, гудамжны гэрэлтүүлгийг сайжруулах, нэмэгдүүлэх
5. ЕБС-ийн хүүхдийн нийтийн тээврээр зорчих асуудлыг шийдвэрлэх, нийтийн тээврийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх
6. Сургуулийн орчинг хүчирхийлэлгүй байлгах арга зүйг захирал, сургалтын менежер, багш, нийгмийн ажилтан, эцэг эх, сурагчдад хэвшүүлэх, сургах талаар арга хэмжээ авах